



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 02 өдөр

Дугаар A/104

Жаргалтхаан

Өвөлжөө, хаваржааны бэлчээрт
мал оруулах хугацааг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2 дахь заалтууд, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12 дугаар хуралдааны "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор өвөлжөө, хаваржааны бэлчээр, ойн санг малаас чөлөөлж, тухайн бүс нутагт мал оруулах хугацааг 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.

2. Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж, нийтээр ашиглах бөгөөд өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг мөрдөж хэрэгжүүлэхийг малчид иргэд, багийн Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401261